



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 04 сарын 27 өдөр

Дугаар А/198

Мөрөн сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.2, 66 дугаар зүйлийн 66.1, Монгол Улсын Их Хурлын 2021 оны 106 дугаар тогтоол, Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 264 дүгээр тогтоол, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 14 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. “Шинэ сэргэлтийн бодлого”-ын хүрээнд Хот, хөдөөгийн сэргэлт зорилтыг хэрэгжүүлэх, “Хөвсгөлд зочлох жил” нэрлэсэн жилийн хүрээнд аялал жуулчлалыг хөгжүүлэх зорилгоор “Хөвсгөлд тавтай морилно уу” арга хэмжээг 2023 оны 05 дугаар сарын 14-15-ны өдрүүдэд Улаанбаатар хотод зохион байгуулсугай.

2. “Хөвсгөлд тавтай морилно уу” арга хэмжээг зохион байгуулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хавсралтаар байгуулсугай.

3. “Хөвсгөлд тавтай морилно уу” арга хэмжээг өргөн цар хүрээтэй, өндөр түвшинд зохион байгуулах үйл ажиллагааг хуулийн хүрээнд боломжит бүх арга хэлбэрээр хэрэгжүүлж, удирдамж, бэлтгэл ажлын төлөвлөгөөг боловсруулан батлуулж, холбогдох тайлан мэдээг 2023 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн дотор танилцуулахыг “Хөвсгөлд тавтай морилно уу” арга хэмжээг зохион байгуулах ажлын хэсэг (М.Хуягбаатар)-т даалгасугай.

4. Тус арга хэмжээг олон нийтэд сурталчлах, иргэдэд мэдээлэл түгээх талаар хэвлэл, мэдээллийн байгууллагатай хамтран ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хэвлэлийн алба (Б.Сарантуяа)-д үүрэг болгосугай.

5. Захирамжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Б.Мөнгөн-Эрдэнэ)-д үүрэг болгосугай.

ДАРГА




Ш.ИДЭРБАЯСГАЛАН

Захирамж-2023

6712010032

Аймгийн Засаг даргын 2023 оны 04
дүгээр сарын 27-ний өдрийн А/198 дүгээр
захирамжийн хавсралт



**“ХӨВСГӨЛД ТАВТАЙ МОРИЛНО УУ” АРГА ХЭМЖЭЭГ
ЗОХИОН БАЙГУУЛАХ АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН**

Ажлын хэсгийн дарга: Аймгийн Засаг даргын орлогч

Гишүүд:

- Аймгийн ЗДТГ-ын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга
- Аймгийн ЗДТГ-ын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга
- Аймгийн ЗДТГ-ын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга
- Аймгийн Соёл, урлагийн газрын дарга
- Аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга
- Аймгийн Байгаль орчин аялал жуулчлалын газрын дарга
- Аймгийн Боловсрол, шинжлэх ухааны газрын дарга
- Аймгийн Хөдөлмөр, халамж, үйлчилгээний газрын дарга
- Аймгийн Хөгжимт драмын театрын дарга
- Аймгийн Орон нутаг судлах музейн дарга
- Хөвсгөл Политехникийн коллежийн захирал
- Аймгийн зураач, урчуудын холбооны төлөөлөл /тохиролцсоноор/
- МҮХАҮТ-ын Хөвсгөл аймаг дахь салбарын дарга /тохиролцсоноор/
- Хөвсгөлийн аялал жуулчлал, зочлох үйлчилгээний холбооны төлөөлөл /тохиролцсоноор/
- Хөвсгөл аймгийн аялал жуулчлал эрхлэгчдийн холбооны төлөөлөл /тохиролцсоноор/

Нарийн бичгийн дарга: Аймгийн Засаг даргын Тамгын газрын
дарга

_____оОо_____